

# Бизнес аялал

Яасан сайхан бэ! Петягийн аав ээж нь бүтэн жил бизнес аяллаар явснаар дүрсгүй жаал ганцаараа үлджээ. Петя туйлын баяртай байлаа. Тэрээр өдөржингөө орон дээр үсэрч цовхчин, дэр шидэлж байлаа. Гэтэл...

Өнөөдөр Петя шургуулгаа нээтэл нэгэн аймшигт зурвас олжээ. Аав ээж нь түүнд үүрэг даалгавар үлдээсэн байж. Жилийн турш өдөр болгон өглөө, өдөр, оройдоо тэдний хайртай цэцгийг услах ёстой байжээ.

"Байзаарай" гэж хэлээд тэр жилийн  $i$ -р сард ( $1 \leq i \leq 12$ ) аав ээжийн даалгаврыг биелүүлбэл цэцэг  $a_i$  см ургана, харин тэр цэцгийг  $i$ -р сард услахгүй бол цэцэг тэр сардаа ургахгүй гэдгийг мэдэв. Мөн цэцэг  $k$  см-ээс бага ургах л юм бол аав ээж нь түүнийг цэцэг усалж байсан гэдэгт итгэхгүй байж болох юм гэдгийг ойлгожээ.

Цэцгийг  $k$  см-ээс багагүй ургуулахын тулд Петя хамгийн багадаа хэдэн сарын турш услах хэрэгтэй болохыг олоход туслаарай.

## Input

Эхний мөр  $k$  ( $0 \leq k \leq 100$ ) бүхэл тоог агуулна. Дараагийн мөр хоосон зайгаар тусгаарлагдсан 12 бүхэл тоог агуулна. Энэ мөрөнд байгаа  $i$ -р ( $1 \leq i \leq 12$ ) тоо нь  $(a_i)$  тоог илтгэнэ.  
 $a_i \quad 0 \leq a_i \leq 100$

## Output

Цэцгийг  $k$  см-ээс багагүй ургуулахын тулд Петя хамгийн багадаа хэдэн сарын турш услах хэрэгтэйг илэрхийлэх бүхэл тоог хэвлэ. Хэрэв цэцэг жилд  $k$  см ургаж чадахааргүй бол "-1" гэж хэвлэнэ үү.

## Example

**Input 1:**

5  
1 1 1 1 2 2 3 2 2 1 1 1

**Output 1:**

2

**Input 2:**

0  
0 0 0 0 0 0 1 1 2 3 0

**Output 2:**

0

**Input 3:**

11  
1 1 4 1 1 5 1 1 4 1 1 1

**Output 3:**

3

